



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 29/01

Арвайхээр сум

**Аймгийн 2024 оны төсөвт тодотгол
хийх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14 дүгээр “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 10 дугаар заалтын 10.2-т заасан “Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 5,389,666.6 (таван тэрбум гурван зуун наян есөн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуу) төгрөгөөр бууруулсугай.

2. Мөн тогтоолын 10 дугаар заалтын 10.4-д заасан “Аймгийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг” 625,825.0 (зургаан зуун хорин таван сая найман зуун хорин таван мянга) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

3. Мөн тогтоолын 1.1.1-т заасан “Автотээврийн болон өөрөө явагч албан хэрэгслийн албан татвар”-ыг 13,000.0 (арван гурван сая) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

4. Мөн тогтоолын 1.1.3-т заасан “Улсын тэмдэгтийн хураамж”-н орлогыг 50,000.0 (тавин сая) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

5. Мөн тогтоолын 1.1.4-т заасан “Аж ахуй нэгжийн орлогын албан татвар-40%”-ыг 500,000.0 (таван зуун сая) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

6. Мөн тогтоолын 1.2.2-т заасан “Хүү, торгуулийн орлого”-ыг 290,000.0 (хоёр зуун ерэн сая) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

7. Мөн тогтоолын 1.2.3-т заасан “Бусад орлого”-ыг 498,136.3 (дөрвөн зуун ерэн найман сая нэг зуун гучин зургаа мянга гурван зуу) төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

8. Тогтоолын 2-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын орлогын хэмжээг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

Д/д	Байгууллагын нэр	Дүн
1	Усан спорт сургалтын төв	84,000.0
2	Сум дундын ойн анги	78,770.0

9. Мөн тогтоолын 3-т заасан “Аймгийн 2024 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа зарим байгууллагын төсвийн өөрчлөлтийг дор дурьдсанаар баталсугай”.

622401084

мянган төгрөг		
Д/д	Нэр	Дүн
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,296,436.4
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4,110,374.6
3	Засаг даргын нөөц хөрөнгийн зардал	454,500.0
4	Автозамын сангийн хөрөнгө оруулалт	833,000.0
5	Сум дундын ойн анги	160,577.9
6	Усан спорт, сургалтын төв	697,519.0
7	Санхүүгийн хяналт, аудитын алба	436,973.3
8	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал	1,130,900.0
9	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал	2,022,700.0
10	Их засварын зардал	1,452,000.0
11	БООТөвийн тогтмол зардал	1,167,841.3
12	Аймгийн улсын төсвийн байгууллагуудын төрийн захиргааны ажилтнуудын орон нутгийн нэмэгдэл	586,572.8
13	Аймгийн орон нутгийн байгууллагуудын төрийн захиргааны ажилтнуудын 5 жилийн тэтгэмж	459,736.0
14	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	122,000.0

10. Тогтоолын 5-д заасан сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

Д/д	Сумын нэр	Мөнгөн дүн (мянган төгрөг)
1	Баян-Өндөр	855,208.1
2	Бүрд	1,010,281.3
3	Бат-Өлзий	968,105.2
4	ББУлаан	997,062.0
5	Баянгол	1,156,959.1
6	Гучин-Ус	1,139,985.4
7	Есөнзүйл	1,084,869.6
8	Өлзийт	993,179.8
9	ЗБУлаан	1,089,399.5
10	Богд	1,102,046.1
11	Нарийнтээл	900,673.1
12	Сант	962,743.2
13	Тарагт	1,122,796.6
14	Төгрөг	1,258,469.6
15	Уянга	932,406.7
16	Хайрхандулаан	1,212,422.9
17	Хужирт	937,410.7
18	Хархорин	527,668.2
Нийт дүн		18,251,687.2

11. Аймгийн 2023 оны төсвийн жилд сумын төсвөөс аймгийн төсвийн орлогот төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

Мянган төгрөг

Д/д	Сумын нэр	Төвлөрүүлэх орлогын дүн
1	Арвайхээр сум	5,720,160.8

12.Тогтоолын 8-д заасан аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

Сумын нэр		Мөнгөн дүн (мянган төгрөг)
1	Баян-Өндөр	434,014.0
2	Бүрд	656,451.3
3	Бат-Өлзий	1,040,259.5
4	Баруунбаян-Улаан	287,924.7
5	Баянгол	237,712.0
6	Гучин-Ус	556,028.4
7	Есөнзүйл	195,410.8
8	Өлзийт	159,031.0
9	Зүүнбаян-Улаан	247,847.7
10	Богд	709,305.5
11	Нарийнтээл	822,214.1
12	Сант	233,534.7
13	Тарагт	324,692.4
14	Төгрөг	666,112.9
15	Уянга	634,285.4
16	Хайрхандулаан	367,227.8
17	Хужирт	292,337.4
18	Хархорин	365,732.0
19	Арвайхээр	997,461.8
ДҮН		9,227,583.4

13. Тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, байгууламж, хөтөлбөр төсөл, арга хэмжээний” зардлын нэмэгдүүлсэн ажлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай. Мөн уг хавсралтын 13-т батлагдсан “Сант сумын цэцэрлэгийн сантехникийн засвар”-ын ажлыг 2025 онд хэрэгжүүлэх болсон тул хасаж, Сант сумын Ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварт шилжүүлэн баталсугай.

14.Тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний” зардлын нэмэгдүүлсэн ажлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

15. Тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ”-ний зардлын нэмэгдүүлсэн ажлыг гуравдугаар хавсралтаар баталсугай. Мөн уг хавсралтын 1-д заасан “Арвайхээр сумын гудамж талбай, сумдын сургууль,цэцэрлэг, дотуур байрны камержуулалтыг нэмэгдүүлэх”-ажлын хэмнэлт 10,0 (арван сая) төгрөг, мөн жагсаалтын 9-т заасан “Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсийн холбооны худаг сувагчлалын ажил”-ын хэмнэлт болох 10,0 (арван сая) төгрөг, мөн жагсаалтын 13-т заасан “Агаарын бохирдлыг бууруулах

хүрээнд Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү олгох” зардлыг 60,0 (жаран сая) төгрөгөөр бууруулж нийт 80,0 (ная сая) төгрөгөөр жагсаалтын 11-т заасан “Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах” зардлыг нэмэгдүүлсүгэй. Мөн уг хавсралтын 8-д заагдсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” ажил нь хийгдэх боломжгүй болсон тул хасаж төлөвлөгөөт бусад ажлыг нэмэгдүүлсүгэй.

16. Тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний Боловсролын салбарын 6-д заагдсан “Политехник коллежийн дотуур байрны засварын 48,0 (дөчин найман сая) төгрөг”-ийн ажил хийгдэх боломжгүй болсон тул хассугай.

17. Орон нутгийн төсөвт орсон өөрчлөлтийг төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ДАРГА


О.ПҮРЭВДОРЖ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн
29/01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**“Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар
хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл,
арга хэмжээний жагсаалт”**

(Мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Аймгийн дотоодын 833 дугаар тусгай салбарт техник, тоног төхөөрөмж худалдан авах	2024	2024	46,700.0	46,700.0
2	Онги-Ус суваг ХК-д цэвэр усны хоёрдугаар өргөлтийн насосны зардал	2024	2024	45,000.0	45,000.0
3	Сант сумын ЕБСургуулийн дотуур байрны дээврийн засвар	2024	2024	74,000.0	74,000.0
4	Аймгийн Гэр бүл, хүний хөгжлийн (Хуримын ордон) төвийн гадна ус, дулаан хангамжийн засвар	2024	2024	100,000.0	100,000.0
5	Арвайхээр сумын гэрлэн дохио, гэрэлтүүлгийн угсралт, суурилуулалтын зардал	2024	2024	50,000.0	50,000.0
6	Сант сумын ЗДТГазрын байрны засварын үлдэгдэл санхүүжилт	2024	2024	23,000.0	23,000.0
Нийт дүн					338,700.0

----oOo----

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн
29/01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

**Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөө
хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга
хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хамрах салбар	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ						
1	Улсын их баяр наадмын зардал (гүйцэтгэлээр дутсан зардалд)	Соёл	2024	2024	125,121.6	55,121.6
2	БОЭТ-ийн Халдвартын эмнэлгийн гадна фасадын засварын нэмэгдэл зардал	Эрүүл мэнд	2024	2024	172,680.0	45,680.0
3	БОЭТ-ийн төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадны засварын нэмэгдэл зардал	Эрүүл мэнд	2024	2024	346,800.0	50,800.0
4	Орон сууцны гадна фасад засварын нэмэгдэл зардал	Нийтийн аж ахуй	2024	2024	489,025.2	49,025.2
5	Цэргийн ангийн халаалтын зуухны өргөтгөл, шинэчлэлт	Нийтийн аж ахуй	2024	2024	100,000.0	100,000.0
6	Туурийн хамгаалалтын хашаа	Соёл	2024	2024	49,703.2	49,703.2
Нийт зардлын дүн						350,330.0

----oOo----

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн
29/01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**“Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар
хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл,
арга хэмжээний жагсаалт”**

(Мянган төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Автозамын засвар, арчлалт, авто зогсоолын зардал	2024	2024		13,000.0
Нийт дүн					13,000.0

----oOo----